



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.5.6, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-63/64/32/А/27 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Сэндбоксыг зохицуулалтын орчин” журмын 3.4, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 242 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Сэндбоксын ажлын хэсгийн удирдамж”-ийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Сэндбоксыг зохицуулалтын орчин” журмын 3.5-д заасан сэндбоксад орох хүсэлтийг хүлээн авч, холбогдох судалгаа, шинжилгээг хийж зөвлөлд хүргүүлэх, сэндбоксын үргэлжлэх хугацаанд оролцогчид хяналт тавих, зөвлөгөө мэдээллээр хангах болон “Сэндбоксын ажлын хэсгийн удирдамж”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Долгорсүрэн Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч;

Ажлын хэсгийн гишүүд:

А.Тамир Мэдээллийн технологийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч;

Р.Цэвэлмаа Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн;

Б.Батмөнх Хяналт шалгалт, зохицуулалтын газрын мэргэжилтэн;

Б.Дөлгөөн Үнэт цаасны газрын мэргэжилтэн;

Х.Тэмүүлэн Банк бус санхүүгийн байгууллагын газрын мэргэжилтэн;

Б.Цолмонтуяа Хяналт шалгалт, зохицуулалтын газрын мэргэжилтэн;

Нарийн бичгийн дарга:

О.Мөнхбат Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн.

151800000378

2. Ажлын хэсгийг шуурхай удирдлагаар ханган, сэндбоксад орох, гарах хүсэлтийг хүлээн авч, холбогдох судалгаа, шинжилгээг хийж санал боловсруулан танилцуулж, сэндбоксын зөвлөлд хүргүүлэхийг Ажлын хэсэг /Б.Долгосүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ